

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

НЭГ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль, заавар журмыг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажилласнаар 2018 оны Үндэсний аудитын газрын санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын шалгалтаар санхүүгийн үйл ажиллагаа хэвийн зөрчилгүй дүгнэлт авсан..

Санхүүгийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг тогтоосон хугацаанд байгуулж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан.

Их сургуулийн 2018 оны 12 дугаар сар, 2019 оны 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн санд хүргүүлэн хянан баталгаажуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны нэгдсэн цахим хуудас, санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан ил тод байдлыг хангасан.

2018 оны 4 дүгээр улирал, 2019 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох мэргэжилтэнээр хянан баталгаажуулж, Сангийн яамны Э-тайланд цахим хэлбэрээр шивж оруулсан ба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг баримтлан, бүх төрлийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн зарчмаар бүртгэсэн ба хөрөнгийг нэрлэсэн үнээр нь болон анхны өртгөөр нь үнэлж, хөрөнгөнд элэгдэл байгуулан элэгдлийн зардлыг бүртгэсэн.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон их сургуулийн мөнгөн кассын сахилга батыг чандлан сахиж, гүйлгээг анхан шатны бүрдэл болсон баримтаар хийж, үлдэгдлийг өдөр тутам гаргуулж, байвал зохих бэлэн мөнгөний хэмжээг 14 хоног тутам тоолж, хяналт тавин удирдлагад танилцуулж хэвшсэн ба “Жижиг мөнгөн сан”-д тогтмол дүүргэлт хийж, тайланг тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн сангийн холбогдох мэргэжилтэнээр хянуулж баталгаажуулан ажилласан.

Бараа материал, мөнгөн хөрөнгийн тайланг хариуцсан нярав нар сар бүр гаргаж, нягтлан бодогч анхан шатны баримтуудтай тулгалт хийж шалган хүлээн авч агуулахын бүртгэлийг баталгаажуулж ажилласан. Мөн хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүрт эд хариуцагчийн карт, тээврийн хэрэгсэл, барилгын хувийн хэрэг, техник тоног төхөөрөмжийн паспортын хөтлөлтийн баяжуулалтыг санхүүгийн баримттай тулгалт хийж ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/280 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын хүрээнд 2018 онд улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу Их сургуулийн захирлын тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан ба уг үнэлгээний хороо худалдан авалтыг зохион байгуулж явуулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын

журмаар тендер зарлаж, ирүүлсэн тендерийн баримт бичгийг нээн хянан үзэж үнэлэн “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг шалгаруулж 5 байгууллагатай, Тагнуулийн ерөнхий газрын 2018 оны 01/166 тоот албан бичгийн дагуу нууцын зэрэглэлд багтаж байгаа хоол, хүнс, сонсогчийн дүрэмт хувцасны бэлтгэн нийлүүлэгч байгуулагуудаас үнийн судалгаа авч харьцуулалтын аргаар бэлтгэн нийлүүлэгчийг сонгосны дагуу 26 байгууллага, хувь хүмүүстэй гэрээ байгуулан худалдан авалтыг зохион байгуулж, хөрөнгийг орлогод авахдаа хүлээн авсан актыг үндэслэн сар бүр тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, худалдан авалтын явцад хяналт тавьж, зөрчлийг арилган гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан.

Өр, авлага үүсгэхгүй ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан ба энэ оны эхэнд 27,9 сая төгрөгийн авлагатай байснаас 2013 оны үүссэн “Моом” ХХК-тай холбоотой 10,3 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар хариуцагч талтай гэрээ байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан удирдамжийн дагуу Үндэсний аудитын газраас 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийгдсэн гүйцэтгэлийн шалгалтанд шаардлагатай санхүүгийн баримт, тушаал шийдвэрийг гарган өгч хамруулсан ба холбогдох албан тушаалтан нарыг бэлэн байлгаж уулзуулж ажилласнаар зөрчилгүй санал дүгнэлт авсан.

Их сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардалагтай 1428 гүйлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн сангаар хянуулж хийсэн бөгөөд гүйлгээний холбогдох баримтын бүрдлийг хангаж ажилласан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 11 сарын байдлаар Их сургуулийн хэмжээнд нийт 6,5 сая төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд 2019 оны ажлын үр дүнгийн урамшуулал олгоход шаардлагатай 150,0 сая төгрөгийг их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. Тэтгэвэрт гарах эрх үүссэн 14 алба хаагчид “Төрийн албаны тухай” хууль, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай” хуулийн дагуу 604,2 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон. Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 21 албан хаагчид 2,1 сая төгрөг, төрөл садан нь нас барсан 54 албан хаагчид нийт 21,1 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг Их сургуулийн дотоод журмын дагуу олгосон бөгөөд харамсалтайгаар амь насаа алдсан 4 албан хаагчийн ар гэрт 209,8 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

ХОЁР. ХӨРӨНГӨ, МАТЕРИАЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 оны үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээг Захиргааны статистикийн мэдээлэл Маягт ТӨ-2, ТӨ-3, ТӨ-6, ТӨ-8.2, 11-ийн дагуу гаргаж цахимаар болон цаасаар хүргүүлсэн.

Дээд боловсролын сургалтын байгууллагын 2018 оны төсвийн зардлын гүйцэтгэл, сургалтын орчны материаллаг баазын статистикийн мэдээллийг батлагдсан ШУТ-5, ШУТ-8, ДБ-6, ДБ-11 маягтаар гаргаж Боловсрол соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Дотоод хэргийн их сургуулийн хооронд байгуулсан 2018 оны өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж 2019 оны гэрээг шинээр байгуулсан.

Шинээр “Хууль сахиулахын их сургуулийн номын сан, спорт заалны барилга” баригдахтай холбогдуулан Их сургуулийн цэргийн гал зуух, спорт заалны барилгуудыг актлуулах саналыг хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй аюулын эрсдэл, мэргэжлийн байгууллагуудыг дүгнэлт, холбогдох бусад баримтуудын хамт Их сургуулийн захирлын 2019 оны 03 дугаар сарын 13-ны 01/469 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 94 дүгээр тогтоол, Их сургуулийн захирлын 2019 оны Б/08 дугаар тушаалын дагуу акталж нураасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 02 сарын 19-ний өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 53 дугаар тогтоолын дагуу “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 154,000,000 төгрөгийн балансын үнэ, 107,760,644.61 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/343, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2019 оны н/01, Их сургуулийн захирлын 2019 оны А/06 дугаар тушаалын дагуу Зэвсэгт хүчний 016 дугаар Бригадаас 4 ширхэг Зил-131 машиныг балансаас балансад шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан.

Спорт заал, Цэргийн гал зуухны барилгыг Их сургуулийн 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Өмч хамгаалах зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж 2019 оны 04 дүгээр сарын 02-ны дугаар 94 тоот тогтоолоор данснаас хасах зөвшөөрөл олгосны дагуу Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Б/08 тоот тушаалаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,037,742,200 /нэг тэрбум гучин долоон сая долоон зуун дөчин хоёр мянга хоёр зуун/ төгрөгийн балансын үнэ, 705,129,108.59 /долоон зуун таван сая нэг зуун хорин есөн мянга нэг зуун найман төгрөг тавин есөн мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий барилга байгууламжийг акталж устгаж данс бүртгэлээс хассан.

Дотоод хэргийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 41 нэр төрлийн машин тоног төхөөрөмж, 45 нэрийн тавилга эд хогшлыг актлах саналыг Их сургуулийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, нийт 63,760,143.67 төгрөгийн машин тоног төхөөрөмж, 46,721,920 төгрөгийн тавилга эд хогшлыг актлах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Их сургуулийн захирлын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны хурлаар шийдвэр гаргуулж Их сургуулийн захирлын 2019 А/19 дугаар тушаалаар нийт 29,779,399 төгрөгийн аж ахуйн материал, 3,032,760 төгрөгийн тусгай зориулалтын материал, 29,955,136 төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, 78,387,030 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлсийг Устгалын байнгын комиссын хяналт дор акталж устгасан.

Батлагдсан төсвийн дагуу урсгал засварын чиглэлээр Сонсогч суралцагчдийн холбооны өрөөний засвар, эрүүл мэндийн төвийн урсгал засвар сайжруулалт, 850 сонсогчийн дотуур байрны дүүшний өрөөг сэргээн засах, Хилийн сургуулийн хилийн албаны танхимийн хуучин өрөөг, цахим лаборатор болгох чиглэлээр танхимийн тохижилт, цэргийн гал тогоог 3000 оюутны хичээлийн шинэ байранд нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой урсгал засвар, 3000 оюутны байранд хүнсний агуулахын засвар, шалган нэвтрүүлэх байрны урсгал засвар, 3000 сонсогчийн хичээлийн байр, 850 сонсогчийн дотуур байрны урсгал засвар, Их сургуулийн шалган нэвтрүүлэх байр, тээврийн хэрэгслүүдийн урсгал засвар, Ахлагчийн сургуулийн үүдний дээврийн засвар зэрэгт нийт 245,9 сая төгрөгийг зарцуулаад байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу Дотоод хэргийн их сургуулийн 2019 оны А/37 дугаар тушаалаар Их сургуулийн эхний хагас жилийн эргэлтийн хөрөнгийн тооллогыг явуулж, тооцоо бодолтыг хийн дүнг Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар оруулж, Захирлын зөвлөлийн хуралд танилцуулсан бөгөөд Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2019 оны А/108 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд явуулж дуусган тооцоо бодолтыг хийсэн.

Дотоод хэргийн их сургуулийн дотуур байрны сонсогчид, бүрэлдэхүүн сургуулиудын хээрийн гаралт, Дотоод хэргийн их сургууль дээр зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, сургалт, зөвлөгөөны хүнсний материалуудыг батлагдсан рапортын дагуу, хугацаанд нь олгож ажилласан. Их сургуулийн бүтэц орон, тоо шинэчлэгдэж албан хаагчдын шилжилт хөдлөгөөн ихээр хийгдсэнтэй холбоотойгоор эд хөрөнгийн картуудыг шинэчлэсэн.

Их сургуулийн албан хаагчдад шаардлагатай бичиг хэргийн материалыг 7 хоног бүрийн Мягмар гаригт шаардах хуудас, зарцуулалтын тайланг үндэслэн олгосон бөгөөд их сургуулийн үйлчлэгдэд шаардлагатай цэвэрлэгээний материалыг сар бүр татаж олгосон.

2019-2020 оны хичээлийн жил элсэн суралцагчдын нормын хувцсыг батлагдсан хуваарийн дагуу тавьж олгосон.

ГУРАВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль батлагдсан холбоотойгоор Их сургуулийн худалдан авах ажиллагааны 2019 оны төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын Худалдан авах ажиллагааны 2019 оны ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/223 дугаар тушаалаар батлуулсан. Уг тушаалын дагуу Дотоод хэргийн их сургууль нь 2019 онд нийт 12 нэр төрлийн 20,778.6 сая төгрөгийн худалдан авалт хийхээс төсвийн хөрөнгө оруулалтаар 18,500.0 сая төгрөг, урсгал төсвөөс 2,241.6 сая төгрөг, бусад хамтран ажилладаг байгууллагуудын санхүүжилтаар 37.1 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн.

Нормын хувцас, зөөлөн эдлэл, хоол хүнс худалдан авах тендер шалгаруулалт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3.е, 13.1.3.ё- д заасны дагуу төрийн нууцад хамаарах тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөхгүй бөгөөд 794.9 сая төгрөгийн худалдан авалт хийгдэхээс нийт 25 байгууллага, хувь хүмүүстэй 789,1 сая төгрөгийн гэрээ байгуулж барааг хүлээн авч гэрээ дүгнэсэн.

Хоол, хүнсний материалын 5 багцын худалдан авах ажиллагааг зохион байгуулж 5 байгууллагатай 952,7 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Хоол, хүнсний материал бэлтгэн нийлүүлэгчидтэй 1 жилийн гэрээ байгуулсан тул 2019 оны 12 дугаар сард гэрээ дүгнэнэ. Хоол хүнсний материал худалдан авах ажиллагаа 100 хувьтай.

Дотоод хэргийн их сургуульд 2019 онд шатахуун бэлтгэн нийлүүлэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог Хууль зүй, дотоод хэргийн яамны мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын 2 төлөөллийг оруулан Их сургуулийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/16 дугаар тушаал байгуулсан бөгөөд үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулан 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр тендерийн урилгыг “Өдрийн сонин” болон tender.gov.mn цахим хуудсанд байршуулан тендерийг зарласан. 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр тендерийг хуулийн хугацаанд нээж 26-ны өдөр үнэлгээний хороог хуралдуулан тендерийг үнэлсэн бөгөөд “Магнай трейд” ХХК, “Сод Монгол групп” ХХК, “Шунхлай трейд” ХХК “Петростар” ХХК гэсэн 4 байгууллагаас 100 хувийн саналаар “Петростар” ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж хүргүүлэн шийдвэрлүүлсний дагуу гэрээ байгуулсан.

Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл нийлүүлэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог Их сургуулийн захирлын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулан алба хаагчдын хувцас, боксын бэлтгэлийн хамгаалалт, биеийн тамирын хэрэгсэл гэсэн 3 багц бүхий цахим тендер шалгаруулалтыг 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарлаж 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр нээсэн. Уг тендер шалгаруулалтад нэг ч байгууллагаас тендер ирүүлээгүй тул хуулийн дагуу дахин зарлаж 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр нээсэн. Тендер шалгаруулалтад дахин тендер ирээгүй тендер шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон тул хуулийн дагуу албан хаагчдын хөдөлмөр хамгааллын хувцасны багцад “Сакура медикал” ХХК, “Их уул трейд” ХХК-уудыг шууд гэрээ байгуулах аргаар сонгож шалгаруулж 3.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

Багаж техник хэрэгсэл худалдан авах 4 багц бүхий тендер шалгаруулалтыг 2019 оны 02 дугаар сарын 28 –ны өдөр цахим систем ашиглан зохион байгуулсан бөгөөд тайзны гэрэлтүүлгийн багцад “Тод баярт” ХХК-ийг сонгон шалгаруулж 21,3 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 3 багцын худалдан авалт амжилтгүй болсон тул ахин тендер зарлаж соёлын төвийн тоног төхөөрөмжийн багцад “Протек” ХХК-ийг сонгон шалгаруулж 139,9 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Үлээвэр хөгжим, хөргүүртэй контейнерийн багцын худалдан

авалт дахин амжилтгүй болсон тул хөргүүртэй контейнерийн багцад “Авто хөргөлт” ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.

Дотуур байранд байрлах сонсогчдын тоо нэмэгдсэн болон Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартуудыг хангах үүднээс цаг үеийн шинж чанартай худалдан авалтуудыг хийсэн бөгөөд нийт 12 байгууллагаас 26,1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шууд худалдан авсан.

Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар, цахимаар зохион байгуулсан бөгөөд 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр нээсэн. Тендер шалгаруулалтад “Ай Ти Зон” ХХК, “Вертексмон” ХХК-иуд тендер ирүүлсэн бөгөөд үнэлгээний хорооны хурлаар хянан үзэж үнэлэхэд бага үнийн санал ирүүлсэн “Вертексмон” ХХК-ыг шалгаруулан 45,0 сая төгрөгийн гэрээ байгуулан тоног төхөөрөмжийг худалдан авсан.

Хувцасны программыг “Геганет” ХХК-аас шууд худалдан авсан.

Эм худалдан авах тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахимаар зохион байгуулсан бөгөөд байгууллагуудаас тендер ирүүлээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болсон. ТБОНӨХБАҮХАТухай хуульд харьцуулалт амжилтгүй болвол шууд гэрээ байгуулна гэж заасны дагуу “Ач үр” ХХК-тай гэрээ байгуулсан.

Бичиг хэргийн худалдан авах тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахимаар зохион байгуулсан бөгөөд tender.gov.mn цахим хуудсанд урилгыг байршуулж тендер зарлахад ганц “Сод пресс” ХХК тендер ирүүлсэн. Ирүүлсэн тендерийг хянан үзэхэд шаардлага хангаж байсан тул захиалагчид зөвлөмж хүргүүлж шийдвэр гаргуулсны дагуу “Сод пресс” ХХК-тай гэрээ байгуулсан.

Тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар, цахимаар зохион байгуулсан бөгөөд хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Хаан даатгал” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн.

Хэрэглэгчийн үнэлгээ хийх байгууллагаар “Мянганы өглөө” НҮТББ-ыг шууд худалдан авах аргаар сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.

Их сургуулийн 2019 оны төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны биелэлт 95 хувьтай, нийт 20,711.3 сая төгрөгийн гэрээ хийгдсэн бөгөөд Их сургуулийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг, үнэлгээний хороодын бүрэлдэхүүнд мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, үнэлгээний хороодод төрийн бус байгууллагын 2 төлөөлөл орж ажилласан бөгөөд ажлын хэсэг, үнэлгээний хороог байнгын бус зохион байгуулалттай байхаар зохион байгуулсан.

ДӨРӨВ. ТӨСӨВ

Дотоод хэргийн их сургуулийн 2020 оны урсгал төсвийг Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоолууд, Их сургуулийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 18076.3 сая төгрөгөөр төсөвлөн боловсруулж, Хууль зүй, дотоод

хэргийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлж нэмэлт баримт тайлбар хийж 2019 оны урсгал төсвөөс 3528,9 сая төгрөг буюу 28.5 хувиар нэмэгдүүлэн 15907,4 сая төгрөгөөр батлуулсан.

Их сургуулийн 2020 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд шинээр ашиглалтад орох “Спорт цогцолбор, номын сангийн барилга” –ын үлдэгдэл санхүүжилт, номын сангийн тавилга, тоног төхөөрөмж, гал тогооны тавилга, тоног төхөөрөмж, усан сангийн тавилга тоног төхөөрөмжийн саналд 22 тэрбум төгрөгийн санал өгч 16,1 тэрбум төгрөгийг батлуулсан.

2019 оны төсвийн хэмнэсэн зардлаас нийт 409,0 сая төгрөгийг Сангийн сайдын тушаалаар төсвийн зарлагын бүлэг хооронд, эх үүсвэр дутагдсан зардлуудад шилжүүлсэн.

2019 оны өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг эхний хагас жилд 74,9 сая төгрөгөөр, сүүлийн хагас жилд 96,0 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн бөгөөд Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах” журам, сангийн сайдын 251 дүгээр тушаалын дагуу үйл ажиллагааны нэмэлт орлогыг буцаан авч зарцуулсан.

Хөрөнгө оруулалт

БНСУ-ын эксим банкны хөнгөлөлттэй зээлээр санхүүжих “3000 сонсогчийн хичээлийн төв байрны тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт” төслийн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 13-ы өдрийн А/26 дугаар тушаалаар батлагдсан. Уг үнэлгээний хороонд тус Их сургуулиас 3 алба хаагч орсон бөгөөд үнэлгээний хорооны эхний хуралдаанаа хийж БНСУ-ын талаас ирүүлсэн тендерийн баримт бичгийг хянан үзэж үнэлсэний дагуу Icraft консорциумыг сонгон шалгаруулсан. БНСУ-ын Эксим банкнаас тус консорциумтай гэрээ байгуулах эрх олгосны дагуу 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр гэрээ байгуулсан.

Их сургуулийн номын сан, спорт цогцолборын барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Их сургуулийн захирлын 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/29 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нь Тагнуулын ерөнхий газраас төрийн нууцад хамаарах барилга барих боломжтой аюулгүй байдлын гэрчилгээтэй байгууллагуудын жагсаалт авах хүсэлтээ хүргүүлсэн бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулан тендерийг зохион байгуулж “Билгүүн Монгол констракшн” ХХК-ийг сонгон шалгаруулж гэрээ барилгын ажил гүйцэтгэх гэрээг Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.

ТАВ. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 1-р сарын 18-ны өдрийн 17-р тогтоолоор баталсан “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын дагуу Их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бие даасан байх, ил тод, нээлттэй байх зарчим дээр тулгуурлан өмнөх оны төсвийн гүйцэтгэл, 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь Сангийн яамны болон Их сургуулийн Шилэн дансанд цахим хэлбэрээр, санхүүгийн мэдээллийн самбарт цаасаар тухай бүр байрлуулсан.

Шилэн дансны тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх үүднээс тус их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2019 оны батлагдсан төсөв, 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалт, 2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 5,0 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээ 139, өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүд 201, 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ, тендерийн ерөнхий мэдээллүүд 76, 2020 оны төсвийн төслийг холбогдох файлуудын хамт Сангийн яамны болон их сургуулийн шилэн данс, санхүүгийн мэдээллийн самбарт тухай бүр цаг хугацаанд нь байршуулан олон нийтэд ил тод мэдээлсэн.

Их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2019 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэл, өглөг, авлагын мэдээг сургуулийн удирдлага, алба хаагч нарт ойлгогдох байдлаар санхүүгийн зардлыг бүлэглэн гаргаж их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлж, хяналт тавих боломжоор ханган ажилласан.

ЗУРГАА. СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ, АЛБАНЫ БЭЛЭН БАЙДАЛ, САХИЛГА ХАРИУЦЛАГА

Тус хэлтсийн 1 алба хаагч Онцгой байдлын сургуулийн бакалаврын эчнээ ангид суралцаж байгаа бөгөөд 1 алба хаагч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим тендерийн сургалт, 1 алба хаагч Авилгатай тэмцэх газрын сургалтад хамрагдсан. 3 алба хаагч худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдан гэрчилгээ авсан.

Санхүү, төлөвлөлтийн албаны алба хаагчид албаны бэлэн байдлыг ханган ажиллаж, Их сургуулийн бие бүрэлдэхүүний өглөөний нэгдэлт, нэгдсэн арга хэмжээнд бүрэн хамрагдсан бөгөөд Их сургуулийн шалган нэвтрүүлэх байрны жижүүр, цэргийн гал тогооны жижүүрийн үүргийг 2 удаа гүйцэтгэсэн.

Нэг албан хаагч Их сургуулийн аврага шалгаруулах волейболын тэмцээнд 3-р байр эзэлж Хүрэл медаль, Олон улсын Иргэний хамгаалалтын өдөр, Монгол Улсад Иргэний хамгаалалтын байгууллага үүсч байгуулагдсаны 55 жилийн ойг тохиолдуулан нийслэлийн хүрээний онцгой байдлын анги, байгууллагуудын офицер бүрэлдэхүүний дунд зохион байгуулагдсан волейболын тэмцээнд амжилттай оролцож 2-р байр эзэлж Мөнгөн медаль тус тус хүртсэн.

Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн албан хаагчид Бүртгэл, санхүү, эдийн засагчдын өдрийг тохиолдуулан Монгол улсын төрийн өмчит их сургуулиудын санхүүгийн албан хаагчдын дунд зохион байгуулагддаг спортын тэмцээн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын

эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын санхүүгийн албан хаагчдын дунд зохион байгуулагддаг спортын тэмцээнүүдэд багаараа амжилттай оролцсон.

САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС